

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН “САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙН ТӨСЛИЙГ ТӨСВИЙН БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХАМТАРСАН ХУРАЛДААНААР  
ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар  
сарын 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийг үндэслэн Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх хэсэгт заасны дагуу хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлснийг нэгтгэн хэлэлцсэн болно.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийн хүрээнд нийт 65.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийг 19 жилийн хугацаатай, 1 хувийн хүүтэй, эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэйгөөр Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан, эдийн засгийн үр өгөөжтэй, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чухал ач холбогдолтой төслүүдийг хэрэгжүүлэхээр боловсруулсан байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар дээрх төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаа боловч хэрэгжүүлэх төслийн 6 нь эрүүл мэндийн салбарт хэрэгжихээр байгааг Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам ямар шалгуур, эрэмбээр төсөл, хөтөлбөрийг сонгосон талаар, боловсролын салбар, мэргэжлийн боловсролын сургуулиудад санхүүжилт шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хэлэлцээрийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, хэлэлцээртэй холбогдуулан зээлийн хөнгөлөлтийн түвшинг нэмэгдүүлэх боломжтой эсэх, зээлийн эргэн төлөлт, шимтгэлийн талаар, нярайн эндэгдлийг бууруулах төслийг хэрэгжүүлснээр эндэгдэл буурах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Монгол Улсын Засгийн газрын нийт өр, зээлийн хэмжээ, жилд ямар хэмжээний төлбөр төлж байгаа талаар, олон улсын гэрээ, хэлэлцээрийн төсөл, эх бичвэр болон холбогдох баримт бичгийг Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн хэлэлцэж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар эрүүл мэндийн салбарт авах өндөр технологийн тоног төхөөрөмжийг ашиглах хүний нөөц, мэргэжилтнүүд байгаа эсэх, эдгээр тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, урсгал зардлын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр Сангийн яамнаас ирүүлсэн 10 төслийг

ямар шалгуураар эрэмбэлсэн талаарх мэдээллийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас бичгээр авах тухай, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн эрүүл мэндийг хамгаалах урьдчилан сэргийлэх ажлууд болох вакцин, анхан шатны оношилгоо шаардлагатай талаар, орчин үеийн тоног төхөөрөмжтэй ажиллах мэргэжилтэн, эмч нарыг нарийн мэргэжлээр гадаадад дунд, богино хугацаагаар сургахад анхаарах, эрүүл мэндийн салбарын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, эмч нарын механик ажиллагааг бууруулах, мэргэжлийн боловсролын асуудал орхигдсон байгаад анхаарах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, 3 дугаар шатлалын эмнэлгүүдийн эмч нарын ур чадвар өндөр, мэргэшсэн байдаг, гэвч тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу байдаг талаар, эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг дэмжиж байгаа талаар үг хэлсэн болно.

Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын "Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгов.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Н.НАРАНБААТАР**

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.ТЭМҮҮЛЭН**